



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2019.12.30 - 2020.01.03

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Шинэ оны амралтын өдрүүдтэй холбоотой арилжааны өдөр цөөхөн байсан өнгөрөгч долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн зарим индексүүд бууралттай байсан бол зарим индекс өсөлттэй байлаа.

Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс бусад индексүүдтэй харьцуулахад өсөлттэй байсан бол зах зээлийн үнэлгээ багатай хэлбэлзэл ихтэй индексүүд бууралттай байлаа. S&P 500 индексийн сагсанд багтах Apple компанийн хувьцаа түүхэн дээд ханшид хүрсэнтэй холбоотой технологийн салбар хамгийн их өсөлт үзүүлээ. Харин материал үйлдвэрлэлийн салбар болон эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцаа уналттай байлаа.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны гэрээнд 01-р сарын 15-ны өдөр гарын үсэг зурсны дараагаар БНХАУ-д айлчлан худалдааны хэлэлцээрийн 2-р үе шатыг хэлэлцэнэ хэмээн мэдэгдсэн нь хөрөнгийн зах зээлийн индексүүдийг өсөлтөд хүргэсэн ч Иран улсын армийн тэргүүлэгч Касим Сулейманид хийсэн АНУ-ын агаарын цохилтоос үүдэн Баасан гарагт хөрөнгийн зах зээлийн индексүүд буурсан байна. Энэхүү агаарын цохилтоос үүдэх тогтворгүй байдал зах зээлд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байгаа ч одоогоор алт болон газрын тосны ханш өссөн байгаа юм.

Европ: АНУ-ын агаарын цохилтоос үүссэн геополитикийн тогтворгүй байдлаас хамаарч Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Мөн энэ долоо хоногт Мягмар гарагт биржүүд эрт хаасан ба Лхагва гарагт амралтын өдөр байсантай холбоотой арилжааны хэмжээ сул байлаа.

Энэ долоо хоногт Евро бүсийн тэр дундаа ХБНГУ-ын 12-р сарын үйлдвэрлэлийн хэмжээ буурсан үзүүлэлт гарсан байна. Тухайн үзүүлэлтийг хэмждэг худалдан авагч менежерүүдийн индекс хүлээгдэж байсан 45.9-өөс их буюу 46.3 байсан ч 11-р сарын үзүүлэлт болох 46.9-өөс буурсан байгаа юм. Энэхүү индекс нь 50-аас бага буюу бууралтын бүсэд сүүлийн 11 сарын турш багтаж байгаа юм.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд Даваа гарагт бууралттай хаагдлаа. (Японы хөрөнгийн биржүүд баярын өдрүүд таарсантай холбоотой Мягмар гарагаас Баасан гараг хүртэл ажиллаагүй ба 1-р сарын 6-ны Даваа гарагаас эхлэн ажиллаж эхлэх юм.)

Япон улсын түүхэнд анх удаа хүн амын 20% буюу 26 сая хүн 70-аас дээш настай байгаа ба Япон улсын хүн ам жилд 500,000-аар буурч байгаа тухай Nikkei агентлагаас мэдээлжээ.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд төв банкнаас заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулснаас үүдэн энэ долоо хоногт өсөлттэй байлаа.

БНХАУ-ын төв банк Лхагва гарагт заавал байлгах нөөцийн хэмжээг 0.5 нэгжээр бууруулсан ба энэхүү шийдвэр нь зах зээлд 800 тэрбум юанийн нийлүүлэлтэд хүргэх юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,511.49	1.67% ▲
Dow Jones	АНУ	28,634.88	-0.04% ▼
S&P 500	АНУ	3,234.85	-0.16% ▼
Nasdaq	АНУ	9,020.77	0.16% ▲
S&P/TSX	Канад	17,066.12	-0.59% ▼
FTSE 100	Их Британи	7,622.40	-0.29% ▼
S&P/ASX 200	Австрали	6,733.50	-1.29% ▼
Nikkei 225	Япон	23,656.62	-0.76% ▼
Hang Seng	Хонг Конг	28,451.50	0.80% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	114.11
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.58
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.63
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.26
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.06
DBM' 2023	USD	7.250%	106.31
TDBM' 2020	USD	9.375%	101.93
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.46

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.714	-0.08 ▼
Libor 3M	1.874	-0.07 ▼
Libor 6M	1.893	-0.03 ▼
Libor 1YR	1.964	-0.04 ▼
US 2YR Bond	1.513	-0.07 ▼
US 3YR Bond	1.521	-0.08 ▼
US 5YR Bond	1.570	-0.11 ▼
US 10YR Bond	1.771	-0.11 ▼

Валютын ханш /төг/

Валют	2020.01.03	Өөрчлөлт
USD	2,735.88	0.09% ▲
CNY	392.29	0.43% ▲
EUR	3,051.46	0.26% ▲
RUB	43.98	-0.27% ▼
KRW	2.34	-0.43% ▼
JPY	25.35	1.52% ▲
CAD	2,110.37	1.19% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,552.20	2.76% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	18.06	1.65% ▲
Зэс	USD/lb.	278.70	-1.50% ▼
Нүүрс	USD/MT	69.47	0.32% ▲
WTI газрын тос	USD/bbl.	63.05	2.15% ▲
Brent газрын тос	USD/bbl.	68.60	0.65% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XI	5.2%
Бодлогын хүү	2019. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XI	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	11.49%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XI	4.80%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	16.88%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XI	10.58%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 633.6 сая төгрөгийн 4,243,945 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Дархан гурил тэжээл” /DAR/ компанийн хувьцаа 32.22%-аар буюу хамгийн ихээр өсөж 4,879.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Хар тарвагатай” /TVT/ компанийн хувьцаа 24.70%-аар буурч 5,000.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

01-р сарын 03-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,666.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,511.49 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.67%-аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	633.6
Зах зээлийн үнэлгээ	2,666,685.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,511.49	1.67% ▲
MSE I индекс	9,500.09	2.90% ▲
MSE II индекс	7,829.09	0.67% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард кредит ББСБ	3,308,229	262,416,137
АПУ	144,605	91,275,301
Ард даатгал	84,730	65,810,760
Ард санхүүгийн нэгдэл	34,824	61,253,838
Монгол шуудан	75,879	52,032,224

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан гурил тэжээл	4,879.00	32.22% ▲
Тахь-Ко	13,100.00	14.91% ▲
Тав	17,500.00	12.90% ▲
Фронттиер лэнд групп	338.44	12.81% ▲
Женко тур бюро	80.00	11.11% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хар тарвагатай	5,000.00	-24.70% ▼
Адуун чулуун	1,180.00	-15.71% ▼
Могойн гол	7,655.00	-14.99% ▼
Инвескор ББСБ	2,210.00	-10.96% ▼
УБ-БҮК	400.00	-9.09% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард секюритиз	522,394,988
Стандарт инвестмент	135,097,002
Голомт капитал	114,104,854
Бумбат-Алтай	102,737,928
Ард капитал групп	80,171,250

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	620.00	659,973
Таван толгой	6,550.00	344,957
МИК Холдинг	15,000.00	310,640
Говь	276.12	215,405
Инвескор ББСБ	2,201.00	157,873

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.12.24-нд олгов
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.12.24-нд олгов
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хянан шалгагчдад зориулсан сургалт боллоо

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн алба хамтран “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ” сэдэвт хянан шалгагч нарын чадавхийг бэхжүүлэх сургалтыг зохион байгууллаа. МУТСТ чиглэлээр хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагуудын хянан шалгагчдын мэдлэгийг дээшлүүлэх, нэгдсэн мэдээлэл өгөх, тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх нь сургалтын зорилго байв. Сургалтын үеэр МУТСТ гэмт хэргийн талаар ерөнхий ойлголт өгч, МУТСТ хяналт шалгалтын тогтолцоо, түүний шинэчлэл, зайны хяналт шалгалт хийх аргачлал, туршлага, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ, хүлээж буй үүрэг, газар дээр хяналт шалгалт хийх тухай, МУТСТ-тэй холбоотой шийтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлсэн Хорооны туршлага, тулгарч буй асуудлууд зэрэг сэдвээр Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, анхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй дотоод хэргийн яам, Терроризмтой тэмцэх зөвлөл зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллүүд илтгэл тавьлаа.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Бодь даатгал” ХХК компанийнхаа 20 хувийг олон нийтэд санал болгож, 5.16 тэрбум төгрөг татан төвлөрүүлнэ

“Бодь даатгал” ХХК Санхүүгийн зохицуулах хорооноос IPO гаргах зөвшөөрлөө авлаа. 1995 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн тус компани олон нийтэд 47 сая ширхэг хувьцааг нэгжийг нь 113 төгрөгөөр санал болгохоор төлөвлөж байгаагаа мэдээллээ.

Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг интеграцчилал, иншүртек, компанийн хөрөнгө оруулалт, бизнес интеллиженс чиглэлээр зарцуулах төлөвлөгөөтэй байна. Тус компани хөрөнгийн зах зээлд гаргах нийт хувьцааны 11.7 сая ширхгийг одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаанаас гаргах бол 15 хувийг шинээр нэмж гаргах юм байна. Ингэснээр компани нийтдээ 235 гаруй сая ширхэг хувьцаатай болж, хөрөнгийн зах зээлд үүнийхээ 20 хувийг олон нийтэд санал болгох юм.

2019 оны III улирлын байдлаар “Бодь даатгал” ХХК-ийн нийт хөрөнгийн хэмжээ 23.9 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь даатгалын болон давхар даатгалын компаниуд дундаа зургаадугаарт бичигдэх дүн болж байгаа аж.

Одоогоор Монголын Хөрөнгийн биржид “Ард даатгал” ХК, “Мандал даатгал” ХК-ийн хувьцаа арилжигдаж байгаа бол Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хорго хайрхан” ХК-ийг “Монгол даатгал” компани өөртөө нэгтгэх үйл явц үргэлжилж байна.

2019 оны III улирлын эцсийн байдлаар даатгалын компаниудын нийт хөрөнгө 373.6 тэрбум төгрөг хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.8 хувиар өсжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Австрали улсын элчин сайдыг хүлээн авч уулзлаа

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Австрали Улсын Элчин сайд Дэйв Воусэн, нэгдүгээр нарийн бичгийн дарга Доктор Алекс Стивенс нарыг хүлээн авч уулзан хамтран ажиллах талаар ярилцлаа.

Уулзалтад Хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар, Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан чиглэлийн ажлын хэсгийнхэн оролцож Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулахын тулд хийж буй ажил, Олон улсын хамтын ажиллагааны бүлэг /ICRG/-тэй тохиролцсон эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн биелүүлж байгаа талаар танилцуулав.

Австрали Улсын Элчин сайд Дэйв Воусэн, Хороо богино хугацаанд дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгааг онцлон дурдаад Олон улсын хамтын ажиллагааны бүлэгтэй тохиролцсон эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотойгоор дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжтойгоо илэрхийллээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Хорго хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12 -р сарын 16-ны өдрийн 372 тоот тогтоолоор “Монгол даатгал” ХХК-ийг “Хорго Хайрхан” ХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, оноосон нэрийг “Монгол даатгал” ХК болгон өөрчлөхөөр болсон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Монголбанк 2019 онд 15.2 тонн үнэт металл худалдан авлаа

Монголбанк 2019 онд 15.2 тонн үнэт металл худалдан авсан нь 2018 онд 21.9 тонн үнэт металл худалдан авснаас 6.7 тонноор бага буюу 30%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 12-р сард 761 кг үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 29 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 2.5 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 2.9 тонн үнэт металл худалдан авч байснаас 2.2 тонноор буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 12-р сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 129,222.85 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк

“Turquoise hill resources”-ийн 9.37 сая ширхэг хувьцааг Торонтогийн хөрөнгийн биржид арилжив

“Оюу Толгой” ХК-ийн хөрөнгө оруулагч “Turquoise Hill Resources”-ийн хувьцааны ханш өнгөрсөн баасан гарагт Торонтогийн Хөрөнгийн биржид арилжааны явцад 5.7 хувиар өссөн боловч арилжааны төгсгөлд нийт дүнгээрээ 1.15 хувиар буурлаа.

Үүний зэрэгцээ тус компанийн хувьцааны зорилтот ханшийг 1.75 канад доллар гэж тооцож байсан “TD Securities” дүгнэлтээ өөрчилж, 1.6 канад доллар болгон бууруулсан байна. Өнгөрсөн баасан гарагт нийт 9.37 сая ширхэг хувьцаа арилжсан нь сүүлийн 20 өдрийн дунджаас гурав дахин давсан дүн болжээ.

“Оюу Толгой” ХК-ийн хөрөнгө оруулагч “Turquoise Hill Resources” болон “Rio Tinto” компаниудын хувьд Монгол Улсын Засгийн газартай яриа хэлэлцээ хийхэд бэлэн гэдгээ мэдэгдэж, хоёр тал ажлын хэсгийн багаа бүрдүүлж байгаа аж.

Эх сурвалж: Монголбанк

Метан хийн эрлийн ажлыг 70 хоногт багтаан дуусгажээ

“Эрдэнэс Монгол” ХХК-ын охин компани “Эрдэнэс метан” Австралийн “Жэйд метан”-тай нүүрсний давхаргын метан хийн эрэл хайгуул, хөрөнгө оруулалтын гэрээг өнгөрсөн тавдугаар сард байгуулсан. Улмаар хоёр тал хамтран “Метан газ ресурс” компанийг байгуулан ажлаа эхэлсэн юм. Тавантолгойн орд газарт метан хийн хайгуул хийх төслийн хөрөнгө оруулалтыг “Жэйд метан” компани бүрэн дааж буй. “Эрдэнэс метан” энэ онд таван цооног өрөмдөхөөр төлөвлөсөн бол Австралийн геологичид ордын геологийн тогтоцтой танилцан, эрлийн талбайг ялгажээ. Ингэснээр хамтран байгуулсан төслийн компани найман талбайд 500-900 метр гүн цооног өрөмдсөн байна. Нийт 5207.7 тууш метр өрөмдөж, 618 ширхэг нүүрсний дээжид метан хийн бүрэн шинжилгээ хийсэн гэнэ.

Тэд хайгуулын үр дүнгийн тайлангаа АМГТГ-ын Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хүлээлгэн өгчээ. Хайгуулын явцад Тавантолгойн ордын нүүрсний давхарга бүрт метан хий байгаа нь илэрсэн байна. Одоогоор төсөл хэрэгжүүлэгчид нөөцийг тогтоохоор үргэлжлүүлэн ажиллаж байгаа аж.

Метан хий нь тортоггүй, үнэргүй, 98 хувийн шаталттай учир хэрэглээнд нэвтрүүлбэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бүрэн шийдвэрлэхээс гадна дотоодын түлшний хэрэгцээг 100 хувь хангах боломжтой гэж үздэг. Метан хийг олборлох явцад ихээхэн ус хуримтлагддаг аж. Үүнийг Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж буй нүүрс баяжуулах үйлдвэрүүдэд нийлүүлэх боломжтой гэнэ. Метан хийн олон улсын зах зээл 2021 он гэхэд таван жилийн өмнөхөөс 5.8 хувиар өснө гэж шинжээчид тооцжээ. Оросын метан хийн зах зээл 34.6, БНХАУ-ынх 14.7, Индонезийнх 14.9, Канадынх 11.1 хувиар өснө гэж таамаглаж буй юм.

Эх сурвалж: Өдрийн сонин

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.